ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурьдсан өгөгдлүүд нь тендерт энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТОӨЗ-ны холбогдох заалт	А.Ерөнхий зүйл
ТОӨЗ 1.1	Захиалагч нь Хэнтий аймгийн Баян-Адарга сум Ерөнхий боловсролын сургууль
ТОӨЗ 1.1	Дотуур байрны хоол, хүнс ХЭАБАСЕБС/202001013
ТОӨЗ 1.2	Энэхүү тендер нь шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ Багцын дугаар Багцын нэр Багцын үнэ Багц 1 Мах, махан бүтээгдэхүүн 12668500 Багц 2 Сүү, Сүүн бүтээгдэхүүн 1749000 Багц 3 Төмс хүнсний ногоо 10102400 Багц 4 Хуурай хүнсний бүтээгдэхүүн 21445600
ТОӨЗ 2.1	Санхүүжилтын эх үүсвэр:Улсын төсвөөс
Б.Тендерийн баримт бичиг	
ТОӨЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй тодруулга авах хаяг: Монгол, Хэнтий Баян-Адарга сум ЕБС 209 тоот
ТОӨЗ 8.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер авах эцсийн хугацаанаас ажлын нэг хоногоос багагүй байна
ТОӨЗ 11.1	Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй тендерийн хэл монгол гадна дараах хэл дээр байна
ТОӨЗ 12.1 ё	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд: 1.Үнийн санал 2.Техникийн тодорхойлолт 3.Санхүүгийн тайлан 4. ААН гэрчилгээ 5.Чанарын баталгаа 6. Татварын тодорхойлолт, жишиг татвар төлсөн баримт 7.Ижил төрлийн бараа нийлүүлж байсан туршлага
ТОӨЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй
ТОӨЗ 15.9а 3б болон в5	Бараа хүргэгдэх эцсийн цэг “ Захиалагчийн агуулах эсвэл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил” Баян-Адарга сумын Дуурлиг баг ЕБСургуулийн дотуур байр

ТОӨЗ 15.10	Тендерт оролцогчдын санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна
ТОӨЗ 16.1	Тендерийн валют төгрөг байна
ТОӨЗ 18.1 А	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл шаардлагагүй
ТОӨЗ 18.1 Б	Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан
ТОӨЗ 19.1.(б)	*9,10,11,4,5,6 саруудад орон нутагт тариалсан хүнсний ногоо, боловсруулсан цагаан идээг нийлүүлсэн байна.*
ТОӨЗ 20.1	Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна
Г.Тендер ирүүлэх	
ТОӨЗ 23.3 б	Тендер хүлээн захиалагчийн хаяг: Баян-Адарга сумын Дуурлиг баг ЕБСургууль Тендер хүлээн авах этгээд: Монгол, Хэнтий Баян-Адарга сум ЕБС Байгууллагын хаяг: Дуурлиг баг Эрчим хороо Өрөөний дугаар: 209
ТОӨЗ 23.3 в	Тендер шалгаруулалтыг ялгах зорилгоор тендерийн гаднах болох доторх дугтуйд нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ. Тендер шалгаруулалтын нэр: Хэнтий аймаг Баян-Адарга сум ЕБС-ийн Дотуур байрны хоол, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх **Тендер шалгаруулалтын дугаар:ХЭАБАСЕБС/202001013**
ТОӨЗ 24.1	**Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь** : Огноо: 2020 оны 3 дугаар сарын 20 Цаг: 11^{00}
Д.Тендерийг нээх үнэлэх	
ТОӨЗ 28.1	Тендерийн нээлт хийх газар: Монгол, Хэнтий Баян-Адарга сум ЕБС 209 тоот Огноо: 2020 оны 3 дугаар сарын 20 Цаг: 11^{30}
Е. Гэрээ байгуулах эрх олгох	
ТОӨЗ 40.1	Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь 20% Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь 20%

Техникийн тодорхойлолт: Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, стандартанд нийцсэн байна

Нэр төрлийн дугаар	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Мах махан бүтээгдэхүүн	Хүнсний эрүүл ахуйн шинжилгээний бичигтэй, стандартын шаардлага хангасан махыг нийлүүлэгч нь өөрийн байр агуулахад нөөцөлж сар бүр сард авах хэмжээгээр нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирэх, хүнсний хуулийг хэрэгжүүлсэн, хадгалалтын хугацааг хянасан, мах нь чийг алдаагүй, хөлдөөсөн, гулууз, гадаргуу нь цэвэр, гадны үнэр амтгүй 1-р зэргийн үхрийн мах байна. Нийт авах махны 70% нь үхрийн мах, 20% нь хонины мах, 10% нь ямааны мах байх шаардлагатай
2	Сүү сүүн бүтээгдэхүүн	Хүнсний эрүүл ахуйн шинжилгээний бичигтэй, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирэх, хүнсний хуулийг хэрэгжүүлсэн, хадгалалтын хугацааг хянасан, зориулалтын саванд савлаж ирэх, гадны үнэр амтгүй, тослог зохих хэмжээнд сүү байна. Сүүг 9,10,11,4,5,6-р саруудад орон нутгийн үйлдвэрлэгч нараас нийлүүлсэн байна Аарц нь цагаан өнгөтэй, хэт исгэсэн биш, савласан болон хөлдүү, цэвэр саванд хадгалсан байна. Аарцыг 11,12,1,2,3,4 саруудад орон нутгаас ханган нийлүүлсэн байна. Тараг нь исээгүй жигд бүтэцтэй, хэт шингэн биш ариун цэврийн шаардлага хангасан уламжлалт аргаар бүрсэн байна. Таргыг 9,10,5,6 саруудад нийлүүлсэн байна. Тайлбар: шингэн сүү, тараг, аарц хамаарна.
3	Хүнсний ногоо	Хүнсний эрүүл ахуйн шинжилгээний бичигтэй,стандартын шаардлага хангасан монгол газрын хөрсөнд тариалагдсан монгол төмс хүнсний ногоо байна. Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирэх, хүнсний хуулийг хэрэгжүүлсэн, хадгалалтын хугацааг хянасан байна.Нийлүүлэгч нь сум орон нутгийн хөрсөнд ургасан хүнсний ногоогоор 9,10,11,12 саруудад ханган нийлүүлсэн байна. **Төмс:** Төмсний диаметр 6-7см багагүй, нэг ширхэг төмс нь 120 граммаас дээш байх, гэмтэж муудаагүй,

		зөөлрөөгүй, соёолоогүй, хүйтний улиралд хайрагдаагүй, гадны үнэр амтгүй, механик хольцгүй, нэг тонн төмс бүрт 10 кг хорогдол тооцож түүнтэй тэнцэх хэмжээний төмс нэмж нийлүүлэх **Байцаа:** Байцаа нь нягтрал сайтай муудаж гэмтээгүй, үнэр амтгүй, өт шавьжгүй элдэв механик хольцгүй байна. Дундаж жин 1,5 кг аас дээш байна **Бөөрөнхий сонгино:** ялзарч муудаагүй, хатаж чийгээ алдаагүй ааг, амт сайтай, гадны элдэв механик хольцгүй байна. **Лууван:** Механик хольцгүй, зөөлөрч муудаагүй, чийгээ алдаагүй, соёолоогүй **Манжин**: Стандартын шаардлага хангасан гэмтээгүй, ялзарч муудаагүй, хөгшрөөгүй байна **Тайлбар:** Дарсан ногоо буюу лаазалсан дахин, боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй.
4	Хуурай хүнс	Хүнсний эрүүл ахуйн шинжилгээний бичигтэй, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирэх, хүнсний хуулийг хэрэгжүүлсэн, хадгалалтын хугацааг хянасан, зориулалтын саванд савласан байна. Гурил 1-р гурил байх бөгөөд 50% нь орон нутагт үйлдвэрлэсэн гурил байна. Гоймонгийн төрөл: Спагите, дун, хөндий, дүрс хэлбэрийн нарийн савхан Нийлүүлэх гоймон нь үйлдвэрийн аргаар боловсруулагдсан олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн байна.0,4-5 кг-аар савлагдсан хуурай хөгцөрч муудаагүй, үйрч гэмтээгүй, хэлбэр дүрсээ алдаагүй шинэ байна. Өндөгний хольцтой урсамтгай биш чанартай байна **Будааны төрөл**: Цагаан, шар, хөц, гурвалжин, хүүхдийн будаа MNS5411: 2004 техникийн шаардлага хангасан байна. Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, хөгцөрч муудаагүй шүдэнд мэдрэгдэх элсэрхэг хатуу зүйлгүй байна. Цагаан будаа том ширхэгтэй агшаахад няцрахгүй байна **Элсэн чихэр**: MNS 5411: 2004 техникийн шаардлага хангасан гадны механик хольцгүй ба үнэр амтгүй байна

		Гурил, гурилан бүтээгдэхүүн: Хүнсний эрүүл ахуйн шинжилгээний бичигтэй, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирэх, хүнсний хуулийг хэрэгжүүлсэн, хадгалалтын хугацааг хянасан, зориулалтын саванд савласан байна **Гурил**: Үйлдвэрийн аргаар боловсруулагдсан, стандартын шаардлага хангасан, цагаан ба шаравтар цагаан туяатай, цагаан үнслэг багатай том ширхэгтэй байна. Зориулалтын MNS-2515:1994 шаардлага хангасан, хөгцөрч нороогүй, хадгалалтын хугацааг хянасан байх **Бусад бараа бүтээгдэхүүн:** Давс, сода, эсгэгч цай, вариань, ургамлын тос, зөгийн бал, жигнэмэг, далайн байцаа, амтлагч, масло, жимс, жимсгэнэ, хуурай сүү,каша Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. Механик гэмтэлд ороогүй, сав баглаа боодол гэмтээгүй, горимын дагуу хадгалагдсан, тунадас үүсээгүй өнгө үзэмж сайтай байна. Бүтээгдэхүүн савласан сав лааз баглааны гадна талд үйлдвэрлэгдсэн он, сар, өдөр харагдахуйц тод байх, хэрэглэх зааврыг дагалдуулж өгөх Тайлбар: Бялуу кекс хамаарахгүй

Оролцогчдод өгөх зааварчилгаа

1.Ажлын цар хүрээ: Ерөнхий боловсролын сургууль нь энэ тендерийн баримт бичгийн ТШӨХ болон техникийн тодорхойлолтод заасан барааг худалдан авах тухай гэрээ байгуулахаар энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.

2. Эрх бүхий оролцогч Тендерийн урилга сонирхсон этгээдэд ил тод байна.Төрийн сангаас зөвхөн аж ахуй нэгжийн дансанд төлбөрийг шилжүүлэх тул сонгон шалгаруултанд оролцож байгаа хүнсний дэлгүүр нь аж ахуй нэгж байна.

3.Оролцогчийн чадвар: Оролцогч гэрээ байгуулах эрх олж авахын тулд дор дурьдсан чадварын шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

-Оролцогч ААН нь эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хангасан хүнсний бүтээгдэхүүнийг худалдаалах бөгөөд гэрээ байгуулснаас хойш гэрээнд заагдсан үнийн саналын дагуу хүнсний бүтээгдэхүүнийг худалдаална.\ААН-ийн гэрчилгээ\

-Худалдах хүнсний бүтээгдэхүүнд чанарын баталгааг албан ёсоор гаргаж ирүүлэх чанарын баталгааг жилээр гаргаж ирүүлэх

-Худалдах хүнсний бүтээгдэхүүний төрөл тус бүрд үнийн санал ирүүлэх

-Худалдах хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрийн үнийн гарал үүслийн нэрийг зааж ирүүлэх. \Техникийн тодорхойлолт\

-Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний хугацаанд тасралтгүй үйлчилгээ үзүүлэх санхүүгийн чадамжитай байх. Сүүлийн нэг жилийн тайлан \ААН\

- Татварын тодорхойлолт жишиг татвар төлсөн тодорхойлолт

4.Үнийн санал авах баримт бичгийн агуулга: Үнийн саналын баримт бичиг нь нэг дор дурьдсан бичиг баримтаас бүрдэнэ

-Үнийн санал авах урилга

-Техникийн тодорхойлолт

-Үнийн саналын маягт

-Гэрээний төсөл

5.Тендерийн иж бүрдэл, түүний дараалал: Оролцогчийн ирүүлэх үнийн санал нь оролцогчдод өгөх зааварчилгааны шалгуур үзүүлэлтийг хангасан материал байна.Үнийн саналын баримт орсон хуудас нэг бүр нь үдэгдсэн дараалын дагуу дугаарлагдсан, баталгаажсан байна. \нүүр, үнийн санал, чанарын баталгаа, татварын санхүүгийн тайлан, тодорхойлолт, татвар төлсөн баримт, аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, бусад\

5.1 Үнийн саналын материалын нүүр хуудас: Энд оролцогч ААН нь тендерийн нэр, шалгаруулалтын дугаар, хугацаанаас өмнө нээж болохгүйг анхааруулсан бичиглэл зэрэг шаардлагатай мэдээллийг товч тусгасан байна.

5.2 Итгэмжлэгдсэн бичиг: Тендерийн бармт бичигт гарын үсэг зурагч этгээд \ захирал-ыг болон түүний итгэмжлэгдсэн хүний гарын үсгийг албан ёсоор оролцогч аж ахуй нэгжийн эрх бүхийн албан тушаалтан баталгаажуулан ирнэ. Итгэмжлэгдсэн хүн нь гэрээ, тендерийн баримт бичиг зэрэг сонгон шалгаруулалттай холбоотой бүх материалд гарын үсэг зурж болно.

5.3 Бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт: Нийлүүлэх барааны нэр төрөл тус бүрийн чанар, гарал үүсэл зэрэг бүтээгдэхүүний техникийн тодорхойлолтод тусгагдсан мэдээллийг агуулсан байх

5.4 Үнийн саналын маягт: Үнийн саналыг урилгад хавсрагдсан маягтын дагуу гаргаж ирүүлнэ

5.5 Санхүүгийн тайлан: Энд сүүлийн нэг жилийн санхүүгийн баталгаажсан санхүүгийн тайлан баланс жишиг татвар төлсөн баримтын хуулбар

6. Үнийн саналын битүүмжлэл ба бичиглэл: Оролцогч нь үнийн саналаа битүүмжилсэн дугтуйд хийж захиалагчид ирүүлнэ.Доторх болон гаднах дугтуйнуудад захиалагчийн хаяг, гэрээний дугаар, тендер шалгаруулалтын өгөгдөл заасан тендер нээх хугацаанаас өмнө нээж болохгүйг анхааруулсан бичигтэй байна.

7. Үнийн санал авах эцсийн хугацаа: Үнийн саналыг захиалагчийн хаягаар 2020 оны 2 дугаар сарын 17 өдрийн 11^{00} цагаас өмнө ирүүлсэн байна. Хугацаа хоцорсон үнийн саналыг нээлгүй буцаана

8.Үнийн саналд нэмэлт өөрчлөлт хийх ба буцааж авах: Үнийн санал хүлээн авах эцсийн хугацаа дуусанаас хойш аливаа үнийн саналд ямар нэгэн өөрчлөлт оруулж болохгүй. Үнийн саналын буцааж авах эрхтэй ба буцааж авах мэдэгдэл хийнэ

9.Үнийн санал нээх: Захиалагч нь үнийн саналын урилгад заасан газар, цаг хугацаанд нээнэ. Нээлтэнд оролцогчийн төлөөлөл байлцах эрхтэй ба бүх оролцогч үнийн саналын нээлтийн тэмдэглэлд гарын үсэг зурна.Нээлтэнд оролцогчийн нэр, үнийн саналыг хэлж үнийн саналыг нээнэ.

10. Үнийн санал үнэлэх ба харьцуулах: Хамгийн сайн үнэлэгдсэн үнийн санал гэж үнийн саналын баримт бичгийн үндсэн шаардлага болон үнийн саналын бичиг баримтын бүх нөхцөл болзол болон техникийн тодорхойлолтын дагуу шаардлага хангасан, хамгийн бага үнийн санал ирүүлсэн үнийн саналыг хэлнэ.

11. Захиалагч үнийн саналаас татгалзах болон хүлээн авах: Захиалагч үнийн саналуудыг үнэлж шаардлага хангасан эсэхийг тогтоох ба шаардлага хангаагүй бүх үнийн саналаас татгалзах эрхтэй. Захиалагч үнийн саналыг хүчинтэй хугацаанд багтаж бүх оролцогчдод албан бичгээр хариу илгээнэ

12. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл: захиалагч нь шалгарсан оролцогчдод гэрээ байгуулах эрх олгох болсныг түүний хүчинтэй хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэл гэрээнд заасны дагуу хийгдэх ажлын үнийн дүнг заана. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хийгдсэнээр оролцогч гэрээнд гарын үсэг зурах хүртэл хэлцэл хийгдсэн байна.

ҮНИЙН САНАЛЫН ЖАГСААЛТ

Огноо.....

Захиалагчийн нэр.....

Захиалагчийн хаяг.....

Нийт өртөг 12668500

№	Бүтээгдэхүүний төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ\ төг
Багц:1 Мах махан бүтээгдэхүүн			
1	Үхрийн мах	1891кг	
2	Хонины мах		
3	Ямааны ма		

Эрх бүхий албан тушаалтны нэр.....

\гарын үсэг, тэмдэг\

Албан тушаал, нэр .....

ҮНИЙН САНАЛЫН ЖАГСААЛТ

Огноо.....

Захиалагчийн нэр.....

Захиалагчийн хаяг.....

Нийт өртөг 1749000

№	Бүтээгдэхүүний төрөл	Тоо ширхэг хэмжээ	Нэгж үнэ\ төг
Багц:1 Сүү сүүн бүтээгдэхүүн			
1	Сүү	490л	
2	Аарц	496кг	
3	Тараг	270л	

Эрх бүхий албан тушаалтны нэр.....

\гарын үсэг, тэмдэг\

Албан тушаал, нэр .....

ҮНИЙН САНАЛЫН ЖАГСААЛТ

Огноо.....

Захиалагчийн нэр.....

Захиалагчийн хаяг.....

Нийт өртөг 10102400

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжээ тоо ш	Нэгж үнэ\ төг
Багц:3 Төмс хүнсний ногоо			
1	Байцаа	2104кг	
2	Төмс	1450кг	
3	Лууван	610кг	
4	Шар манжин	502кг	
5	Сонгино	486кг	
6	Чинжүү	557кг	

Эрх бүхий албан тушаалтны нэр.....

\гарын үсэг, тэмдэг\

Албан тушаал, нэр .....

ҮНИЙН САНАЛЫН ЖАГСААЛТ

Огноо.....

Захиалагчийн нэр.....

Захиалагчийн хаяг.....

Нийт өртөг 21445000

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжээ ш	Нэгж үнэ\ төг
1	Гурил	2850кг	-
2	Давс	114кг	-
3	Хуурай цай	35ш	-
4	Өгөөж боов	748уут	-
5	Луувангийн салат	192ш	-
6	Чацаргана \био\	120ш	-
7	Элсэн чихэр	400кг	-
8	Цагаан будаа	425кг	-
9	Шар будаа	150кг	-
10	Гурвалжин будаа	100кг	-
11	Хөц будаа	100кг	-
12	Гоймон	130кг	-
13	Туузан гоймон	100ш	-
14	Цөцгийн тос	140кг	-
15	Наранцэцгийн тос	228л	-
16	Ургамлын тос боорцог	300 кг	-
17	Эсгэгч	320ш	-
18	Томад	114ш	-
19	Үзэм	64кг	-
20	Каша	100ш	-
21	Хуурай сүү	360ш	-
22	Далайн байцаа	192ш	
23	Шөлний байцай	96ш	
24	Огурцы	96ш	
25	Вандуй	96ш	
26	Тахианы мөч	163кг	
27	Сармис	224ш	
28	Элгэн тараг	45ш	
29	Вариань	200ш	
30	Жимсний чанамал	120ш	

Эрх бүхий албан тушаалтны нэр.....

\гарын үсэг, тэмдэг\

Албан тушаал, нэр .....